



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 13/01

Пионер толгой

Г Газар зохион байгуулалтын Г
2023 оны төлөвлөгөөнд нэмэлт
оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.17, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 13 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилгын газрын байршлыг одоо байгаа барилгын зүүн талд тогтоож зургийг хавсралтаар баталсугай.

2. Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Эрүүл мэндийн төвийн шинээр баригдах барилгын газрын байршлыг нэмж тусган хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Гантулга), Газрын даамлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Отгончимэг) нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА  Ч.ЭРДЭНЭ-ОЧИР



648801014

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны ээлжит бус 13 дугаар
хуралдааны 13/01 дүгээр тогтоолын
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ШИНЭЭР БАРИГДАХ
БАРИЛГЫН ГАЗРЫН БАЙРШИЛ ЗУРАГ

